

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2024.11.18

Өвт

2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11 цаг 00 минутад сумын Соёлын төвд Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх Нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэв.

Төсвийн хяналтын нийтийн сонсголын зохион байгуулагчаар иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Ц.Чинбаяр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сонсгол даргалагчаар ИТХ-ын төлөөлөгч Д.Бадамбаяр, дуудагдаж ирсэн албан тушаалтнаар ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэ, Нягтлан бодогч О.Отгонтуяа 1-р багийн Засаг Ж.Нямтогтох, 2-р багийн Засаг дарга Д.Бямбасүрэн, эрчим техникч Д.Мөнх, “Хансэнтэй” ХХК-ийн захирал Ж.Доржгив нар, оролцогчоор Б.Дамдин, Ж.Ганчулуун, Х.Дагвадулам ажиглагчаар 37 иргэн, албан хаагч оролцлоо. Сонсголын үйл ажиллагааг нээж ИТХ-ын дарга Ц.Чинбаяр үг хэллээ.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ц.Чинбаяр /ИТХ-ын дарга/: Нийтийн сонсголын гол зорилго нь иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлэх, 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангахад оршино. Нийтийн сонсголыг 2023 онд Эрүүл мэндийн 2022 оны төсвийн зарцуулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд зохион байгуулсан. Энэ жил “Хог хаягдлын хураамжийн 2022, 2023 оны хэрэгжилт, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх төсвийн хяналт, хогны менежмент” зохион байгуулж ажиллалаа. Сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулдаг.

Өнөөдөр 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилд сонсголыг зохион байгуулж байна.

Д.Бадамбаяр Сонсгол даргалагч: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар хуралдаанаар товыг тогтоосон. Сумын ИТХ-ын Нийтийн сонсголыг дэгийг уншиж танилцуулав. Дэгийг хавсаргав.

Нийтийн сонсголд хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан Сонсголд оролцогчид үг хэлэхдээ 5 минут, амаар болон бичгээр асуулт асууж болно. Асуулт 4 минут, дараагийн удаа 1 минут, үг хэлэхдээ 3 минут байна.

Ажиглагчид үг хэлж, асуулт асуухгүй. Ингээд үйл ажиллагаандаа оръё. Сумын ОНХС-ийн нягтлан бодогч Б.Пүрэвсүрэн 2023 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын талаар мэдээлэл хийнэ.

Б.Пүрэвсүрэн Үдүүдагдсан албан тушаалтан, Санхүү албаны дарга\: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. ОНХСангийн санхүүжилт 713,410,200 төгрөгийн эх үүсвэрээр дараах ажлууд хийгдсэн. Рамын дэнж, наймаа буланд үерийн далантай болох ажилд 162,167,500 төгрөг тус ажлыг “Тулгат зам” ХХК хийж гүйцэтгэсэн, Ерөнхий боловсролын сургуулийн заал засварын ажлыг “Өндөр буянт хайрхан” ХХК хийж гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл санхүүжилт 29,800,000 төгрөг, Өвтийн голын голдирол өөрчлөх ажлыг “Тулгат зам” 36,000,000 төгрөгөөр хийж гүйцэтгэсэн, Сумын төвийн гэрэлтүүлгийн ажлыг “Оджи-Од” ХХК 78,882,000 төгрөгөөр Сургуулийн арын замын дагуу, Цаг уур, наймаа булангийн 3-р гудамж, өвтийн 17 дугаар гудамж, бэлийн 11 дүгээр гудамжаас хойш нийт 37 гэрэлтүүлэг хийгдсэн мөн тус газар Цамхагт гэрэлтүүлэг Цех-2, Цаг-Уурт-1, ЗДТГ-ын баруун талд 1, урд талбайд 1, Үржүүлэхэд 1 ширхэг нийт 6 цамхагт гэрэлтүүлгийг 17,882,000 төгрөгөөр, Сумын төвийн гэрэлтүүлэг засварын ажлыг “Мөнхийн-Илч гэрэл” ХХК 7,800,000 төгрөгөөр, ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээнд “ТҮЦ” машин 24,000,000 төгрөгөөр “Нью компас” ХХК, Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тавилга эд, хогшлыг “Гурван хэц булаг” ХХК 15,959,600 төгрөгөөр нийлүүлсэн, Улиастай багийн Уурагтын даваа, Хүрдэтийн хошуу, Дээд-Ар жалга, Шавартын хэжлэг, Амгалангийн богч, Дэнжийн-Уруулга, Дунд-Ар жалга зэрэг замыг иргэн Б.Түвшинжаргал 10,000,000 төгрөгөөр, Зөрүүлэг багийн төвийн урд голд гүүр тавих ажлыг “Мотор сервис” ХХК 120,000,000 төгрөгөөр, Хөнөгийн голын гүүр засах ажлыг “Хансэнтний” ХХК хийж гүйцэтгэж байгаа үүний 60 хувийн санхүүжилт буюу 19,000,000 төгрөг, Сумын төвийн золбин нохой, муур устгах ажлыг 7,000,000 төгрөгөөр, ХАА, газар тариаланд шаардлагатай Трактор “Мөнх ногоон тал” ХХК 81,975,000 төгрөгөөр, Бугатын зам засах ажлыг “Хансэнтний” ХХК хийж гүйцэтгэж байгаа үүний 60 хувийн санхүүжилт буюу 18,800,000 төгрөг, Өвтийн давааны Улаан хад, Өвтийн даваа засах ажилд 2,900,000 төгрөгөөр хийгдсэн. ОНХС-аас 2023 онд хийгдээгүй үлдсэн 3 ажил байна. Бүрэгтий багийн өндөр хүчдэлд холбох, тог татах ажил, Сумын төвийг танилцуулах, сурталчилах, өндөрлөгтэй болох ажил, Хөл бөмбөгийн талбайтай болох ажил зэргүүдийн тендерийг 3-4 удаа зарласан боловч гүйцэтгэгч аж ахуйн нэгж оролцоогүй. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийж хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд Бүрэгтий, Урд-Агуйтын ам, Төмөрт, Хужиртын 5 худагт засварын ажил хийж тоног

төхөөрөмжийн материалыг “Улиастайн буян хишиг” ХХК 15,000,000 төгрөгөөр, Малын чанар сайжруулахад зориулагдсан малыг ялган ангилах тоног төхөөрөмжийг “Эко надмид” ХХК 4,950,000 төгрөгөөр, Ногоон тэжээл тарих, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг “Хутагт-Уулын Өгөөж” ХХК 3,000,000 төгрөгөөр, Урд-Агуйт, Цагаан гол, Намагийн булагийн эх хаших, Онгоцот, Бүрдний булгийн эх хаших ажлуудыг Б.Чимэд-Очир 12,000,000 төгрөгөөр, Малчид иргэдэд 10,150,000 төгрөгөөр сургалт, Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мал тарилгын ажлыг “Хутагт-Уулын өгөөж”, “Хустын рашаан” мал эмнэлэгийн аж ахуйн 14,493,800 төгрөгөөр 6 багт мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн 2023 оны малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх байсан үлдсэн ажлууд Зөрүүлэг багийн Галт, Гуяын нуруу, Бүрэгтий багийн Билүүтийн хөндлөн, Улиастай баг Улиастай дэнжид худаг цооног гаргах ажлын тендерийн 4 удаа зарласан боловч гүйцэтгэгч аж ахуйн нэгж оролцоогүй. Сумын төвд мал тарилгын хашаа барих ажил малын тоо толгойн албан татвар оройтож төвлөрсөнтэй холбоотой хэмээн тайлбарлав.

Д.Бадамбаяр/Сонсгол даргалагч\ : Нягтлан бодогч Пүрэвсүрэнд баярлалаа. Оролцогчид 5 минутад багтааж үг хэлнэ. Мэдээлэлтэй холбоотой асуулт, санал байна уу.

Б.Дамдин\оролцогч\ : Малчдын сургалт зохион байгуулсан төсөв нь 10,150,000 төгрөгөөр хаана ямар сургалт хэн зохион байгуулсан бэ? Ямар сургалт гэхээрээ ийм төсөвтэй сургалт байдаг байна. Хэдэн хүн хамрагдсан гэх мэт мэдээлэл дэлгэрэнгүй өгнө үү.

Д.Бадамбаяр\Сонсгол даргалагч\ : Оролцогч Дамдингийн асуултад Засаг дарга Н.Орхонтуул мэдээлэл өгнө үү

Н.Орхонтуул \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга\ : Нийтийн сонсголд хүрэлцэн ирсэн нийт иргэд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Нийтийн сонсгол зохион байгуулж буй ИТХ-ын ажлын албанд баярлалаа. Энэ төсөв нь их харагдаж байгаа боловч 6 багийн хэмжээнд хувааж ойлгон уу. Бүрэгтий 2 дугаар багийн иргэн С.Даваням нь монгол гутлын сургалтыг 2 удаа зохион байгуулсан, мөн Малчдад малын эрүүл мэндийн талаар сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулсан.

Д.Бадамбаяр\Сонсгол даргалагч\ : За баярлалаа. Дараагийн оролцогч Ж.Ганчулуун асуултаа асуун уу.

Ж.Ганчулуун /оролцогч\ : Гэрэлтүүлэг зарим хэсэг нь асахгүй байна. Хаагуур засвар хийгдсэн хаагуур асахгүй байгаа талаар судалгаа байгаа юу 7,8 сая төгрөгт ямар ямар засвар үйлчилгээ хийгдсэн бэ.

Д.Бадамбаяр \сонсгол даргалагч\ : Ганчулууны асуултад Д.Мөнх хариулна уу.

Д.Мөнх \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\ Гэрэлтүүлэг засварын ажил үйлчилгээг 100 хувь хийгдсэн. Урсгал засвар, Шатсан, машин тэрэг дайрсан гэрлийн шонгуудыг засварлах гэх мэт ажлууд хийгдсэн. Нэмж мэдээлэл Тамгын газраас хийнэ.

Н.Бат-Эрдэнэ\Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга\ Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2 тусгалтай гэрэлтүүлэг 2 ширхэг нэмсэн, 6 талт цамхагт гэрэлтүүлэг хийгдсэн. Тухайн үед бүрэн ажиллаж байсан. Одоогийн байдлаар зарим гэрэлтүүлэг асахгүй болоод байна. Гадны компаниар засвар үйлчилгээ хийлгэхээр өртөг өндөр, буцаагаад засвар үйлчилгээ хийх хүн олдохгүй хэцүү байдаг тиймээс сумын компаниар хийлгэхээр эзэнтэй дор бүр нь засварлаад яваад байх боломжтой. Одоо асахгүй байгаа гэрэлтүүлгүүдийг шат дараалалтай засварлаж байна.

Д.Бадамбаяр \сонсгол даргалагч\ Оролцогч Дамдиныг урьж байна.

Б.Дамдин \оролцогч\ Засварын ажил ч бай, шинээр гүйцэтгэсэн ажил ч бай ядаж жилийн баталгаатай байр ёстой жил ч болохгүй яасан ч олон гэрэл шатаж асахгүй болдог юм. Мөн гэрлийн шонгууд дайрч эвдэлсэн эздийн олж өөрсдөөр нь засуулж баймаар байна.

Н.Бат-Эрдэнэ\Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга\ Харин тиймээ эзний олж тогтоож өөрсдөөр нь янзлуулах арга хэмжээ авч баймаар байна. 2023 онд засварласан гэрэлтүүлгүүд 100 хувь асаж байгаа. Энэ онд сумын төвийн камержуулах ажил хийгдэнэ камергүй болохоор үнэхээр хэцүү байна.

Д.Бадамбаяр \Сонсгол даргалагч\ за баярлалаа. Оролцогч Дагвадуламыг урьж байна.

Х.Дагвадулам \Оролцогч\ Хөнөгийн голын гүүрний асуудал өмнө оны төсвөөс 60 хувийн санхүүжилтээ авсан хэр нь тухай ондоо хийж гүйцэтгээгүй энэ онд хийсэн гүүр нь ямар ч стандарт байхгүй техникийн тодорхойлолтын дагуу биш тэр гүүр арай биш ээ?

Д.Бадамбаяр \сонсгол даргалагч\ Засаг дарга асуултад хариулна уу.

Н.Орхонтуул \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга\ Тус ажлыг 2023 онд шууд худалдан авалтын аргаар шалгаруулж “Их сумт хайрхан” шалгарсан боловч хийхээс татгалзаж “Хансэнтэй” ХХК-тай гэрээ байгуулсан. 70 хувийн санхүүжилтийн өгөөд байна үлдсэн 30 хувийн санхүүжилтийг өгөөгүй байгаа өмнөх Засаг дарга шүүхэд мэдэгдсэн байгаа. Тус ажил нь техникийн тодорхойлолтын дагуу хийгдээгүй тухайн багийн иргэд болон багийн Засаг дарга хяналт тавьж ажилласан. Гүйцэтгэгч компанийн талаас нэмж мэдээлэл өгнө үү.

Ж.Доржгив / Дуудагдаж ирсэн албан тушаалтан/: Манай компани “Бугатын зам засах” тендерийг тухайн үед авч байсан уг ажлаа гүйцэтгэж байхад Хөнөгийн голын гүүр засварын гүйцэтгэгч компани хийхгүй болсон учир танайх хий гэсэн. Тус гүүрний бетон цутгалтад 18 сая төгрөг яагаад ч хүрэхгүй нарийхан хийсэн.

Б.Дамдин \Оролцогч/: Тус ажил нь гүүр барих биш хуучин гүүрийг засварлах төсөл арга хэмжээ л юм шиг байх юм. Шинээр барьсан гүүр хэдэн метрийн өргөнтэй вэ? Хурлын хяналт шалгалтын ажлын хэсэг зун очиж хяналт хийхэд 2,30 метр өргөнтэй жижиг тэрэг арай гэж багтаж байсан. Үүнээс хойш янзалсан уу, захиалагч газар ИТХ-аас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан уу? Хяналт тавьсан уу.

Ж.Нямтогтох / Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Багийн Засаг дарга/: Тус гүүрийг хийж байх явцад миний бие удаа дараа хяналт тавьж гүйцэтгэгч компанид хэлсэн энэ хүн миний үгийг хүлээж аваагүй. Техникийн тодорхойлолтод гүүрний урт 20 метр гүйцэтгэгч газар 10 метр хийсэн, өргөн нь 4 метр байсан 2,30 метр хийсэн. Миний үгийг тоож авахгүй хүн гэж тоохгүй юм байна лээ.

Ж.Доржгив / Дуудагдаж ирсэн албан тушаалтан/: Надад тус ажлыг хийхэд техникийн тодорхойлолт өгөөгүй. Ажлаа хийж дуусгал хүлээлгэж өгөх гэсэн чинь техник тодорхойлолт гээл гараад ирсэн.

Н.Орхонтуул \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Гүйцэтгэгч тал ингэж худлаа ярьж болохгүй шүү бид үнийн санал хүргүүлэх тоот хүргэхэд техникийн тодорхойлолтыг хамт хүргүүлсэн сүүлд гэрээ байгуулахад хүртэл өгсөн.

Ж.Ганчулуун /оролцогч/: Техникийн тодорхойлолт өгөөгүй гэж байна. Багийн Засаг дарга Ж.Нямтогтох дарга хяналт тавьсан гэж байна. Иргэд хохирох ёсгүй шүү.

Н.Орхонтуул \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Засаг Төрийн алба залгамж халаатай учраас өмнөх Засаг даргын захирамж гаргасан. Шаардлага хангаагүй учраас хүлээж аваагүй. Цаашдаа техникийн тодорхойлолтын дагуу өргөн болгох байх гэж бодож байна.

Д.Бадамбаяр \сонсгол даргалагч/: За гүүр барьсан стандартын шаардлага хангаагүй, хүлээж аваагүй юм байна. За дараагийн асуудал. Оролцогч Дагвадулам асуултаа асуун уу.

Х.Дагвадулам /Оролцогч/: Худаг усны асуудал тендер зарласан яагаад хийгдэхгүй байна.

Д.Бадамбаяр \сонсгол даргалагч/: Асуултад нягтлан бодогч Пүрэвсүрэн хариу өгнө үү.

Б.Пүрэвсүрэн \дуудагдсан албан тушаалтан/: Тус төсөл арга хэмжээний

тендерийг 3-4 удаа зарласан боловч гүйцэтгэгч газар оролцоогүй. Энэ онд хийгдэж байна.

Дамдин /Оролцогч/: Нэлээн олон худаг цэгийн ажил байна.

Н.Орхонтуул /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: 2023 оны төсөв хүрээгүй учир 2024 онд хийхээр шилжүүлсэн байгаа.

Х.Дагвадулам /Оролцогч/: Өндөрлөг яасан бэ. Тендер хэдэн удаа зарлагдсан.

Н.Орхонтуул /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Өндөрлөг дээр зураг төсөв хийгдсэн. Он дамжаад явж байгаа 2 онд нийлээд 5,6 удаа зарласан боловч гүйцэтгэх газар орж ирэхгүй байна. Энэ асуудлыг ИТХ-ын төсвийн хурлаар цаашид яах талаар ярилцаад явна.

Ж.Ганчулуун /Оролцогч/: Хүнсний зоорь гээд жил бүр нэмээд байх юм энэ дээр Тамгын газрын даргаас хариулт авъя.

Н.Бат-Эрдэнэ /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга/: Хүнсний зоорь дээр аймгийн бичил төслөөс 50 хувь, ОНХС-аас 50 хувь гарсан. Хүлээж авах ажлын хэсэг чанарын хэмжээнд хийгдсэн гээд аймгийн Хөгжлийн бодлого, хүлээж авсан. Хүлээн авсны дараа төмс хийсэн хөлдсөн. Аймгийн ХХААГ, ХБГ-т албан бичиг хүргүүлсэн. Аймаг болохоор яг стандартад нийцсэн гээд байгаа.

Ж.Ганчулуун /Оролцогч/: Өвтийн улаан хадны замыг ямар газар хийсэн бэ. Би дэргэд нь амьдардаг учраас асууж байна.

Н.Бат-Эрдэнэ /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга/: Шууд гэрээгээр ТҮК хийж байсан.

Б.Дамдин /Оролцогч/: Нохой устгаад байдаг энэ муурын асуудлыг яаж шийдэх вэ.

Н.Орхонтуул /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Хавар нохой, муур устгах Засаг даргын захирамж гарч Засаг даргын орлогч, Багийн Засаг дарга нар хамтраад ажилласан. Муур илүү үнэтэй мөн барьж л авч устгахгүй бол суманд оногдохгүй их хэцүү.

Х.Дагвадулам /Оролцогч/: Малын өсөлт, малын чанар дээр хэрхэн анхаарч байгаа вэ. Сая малыг ялган ангилах тоног төхөөрөмж авсан гэсэн ямар төхөөрөмж авсан бэ.

Н.Орхонтуул /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Малын пүү, Циркуль, Палкметр, Лентметр авсан. Хуц, ухна дээр суурь дээр нь очиж хэмжилт хийж байгаа.

Б.Дамдин /Оролцогч/: Ногоон тэжээл тариалах, сумын фондод гэрээгээр

авдаг юмуу.

Н.Орхонтуул /Дуудагдаж ирсэн албан тушаалтан, Засаг дарга/: Билүүтийн хөндлөн, Онгоцотын атаршсан газруудад ногоон тэжээл тарьж байна. “Хутагт Уулын өгөөж” ХХК тарьдаг. Гэрээгээр нөөц бүрдүүлэлтээ хийдэг.

Д.Бадамбаяр /сонсгол даргалагч/: За баярлалаа. Оролцогч нар дүгнэлтээ хэлнэ үү.

Санал дүгнэлт:

Х.Дагвадулам /Оролцогч/: Оролцогч бид 3 нийлээд нэгдсэн дүгнэлт гаргалаа.

2023 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 19 төсөвт арга хэмжээ байна. Үүнээс төсөвт өртөг хүрээгүй 4 ажил хойшлогдсон, хийгдсэн боловч шаардлага хангаагүй 1 ажил байна. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөвт ажил дээр хяналтын ажлын хэсэг гаргаж гүйцэтгэгч талын ажилд захиалагч талаас хяналт сайн тавьж баймаар байна. Техникийн тодорхойлолтын дагуу хийгдэхгүй, чанарын шаардлага хангаагүй ажилд хариуцлага хүлээлгэдэг баймаар байна.

Д.Бадамбаяр /сонсгол даргалагч/: Санал хариулт авч дууслаа. Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон нийт оролцогчдооо баярлалаа.

Ц.Чинбаяр /зохион байгуулагч/: Сонсгол энэ хүрээнд өндөрлөж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвөөр хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тодорхой хэмжээний чиглэл, ойлголттой боллоо.

Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэд та бүхэндээ баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Нийтийн сонсгол 14:25 минутад өндөрлөв.



ИТХ-ЫН ДАРГА Ц.ЧИНБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН Г.СУГАР